



THE WORLD OF THE LOTUS SUTRA

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар

Газрын доороос гарсан бодисадва нарын зүйл хэмээх 15-р бүлэг

Энэ бүлгээс “Үндсэн үүд” хэмээх хэсэг эхлэх ба энэ хэсэгт Буддагийн жинхэнэ дүр тодорхой болдог. Энэ бүлгийн эхний хагас нь Үндсэн үүд хэсгийн оршил хэсэг болж, сүүлийн хагасаас “Буяны зүйл хэмээх 17-р бүлэг”-ийн эхний хагас хүртэлх хэсэг нь гол хэсэг болдог.

Амгалангаар суусны зүйл бүлэгт Шагжамүни будда сургаалаа айлдаж дуусмагц өөр орноос ирсэн хязгааргүй олон бодисадва нар суудлаасаа босож алга хавсран мөргөөд, бурханыг нөгчсөний дараа энэ Шамбалын ертөнцөд Цагаан Лянхуа судрыг айлдан түгээхээ андгайлдаг.

Үүнийг сонссон Шагжамүни будда тэдний хүсэлтээс эрс татгалзаж, “Энэ Шамбалын ертөнцөд угийн маш олон бодисадва нар байгаа бөгөөд тэдгээр бодисадва нар л энэ ертөнцөд Цагаан Лянхуа судрыг дэлгэрүүлэх үүрэгтэй” хэмээн хариулав. Ингэж хэлмэгц газар цуурч, ангал үүсч дотроос нь хязгааргүй олон бодисадва нар гарч ирэв. Тэдний бүх бие алтан шаргал өнгөөр гялалзаж, бурхан багштай адил ариун нандин гайхамшигт дүрийг цогцлоосон байх бөлгөө.

Тэдгээр бодисадва нар Шамбалын ертөнцийн газар дор байсан бөгөөд бурхан багшийн үгийг сонсоод үгэр түргэн бурхан багшийн дэргэд очсон нь энэ байв. Тэр дотор эрдэм оюунаараа гайхагдсан 4 бодисадва байх ба Дээд үйл, Хязгааргүйн үйл, Ариун үйл, Амарлингуйн үйл хэмээнэ.

Газар доороос гарч ирсэн бодисадва нар мэдлэг чадвараараа гайхагдсан болохыг харсан Манзушир бодисадва болон бусад бодисадва нар тэдгээр бодисадва нар хэний шавь юм бол хэмээн гайхширцгааж, түүнийгээ Шагжамүни буддагаас асуув.

Шагжамүни будда “Чи маш чухал асуулт асуулаа. Одоо ингээд Буддагийн жинхэнэ

дүрийг ил тод болгох цаг иржээ. Өнөөг хүртэл айлдаж байгаагүй зүйлийг одоо би айлдах тул анхааралтай сонсогтун” гэв. Тэгээд “Би бээр энэхүү Шамбалын ертөнцөд гэгээрлийг олсны дараа эдгээр бодисадва нарыг бурханы замд оруулсан юм” хэмээн хариулж, тэдгээр бодисадва нарын сахил, чадвар ямар гайхамшигтай болохыг тайлбарлав.

Манзушир бодисадва болон бусад бодисадва нар үүнийг сонсоод ихэд гайхан, Шагжамүни буддагаас дахин асуув. “Бурхан багш та гэгээрлийг олсноос хойш ердөө л 40 жил болоод байгаа билээ. Энэ богинохон хугацаанд яаж эдгээр олон бодисадва нарт бурханы оюун ухааныг гэгээрүүлсэн юм бэ? Жишээ нь 25 настай хүн 100 настай хүнийг өөрийнхөө хүүхэд гээд, 100 настай хүн нь тэр залууг өөрийнхөө эцэг гэх нь итгэхийн аргагүй зүйл билээ. Багш таны хэлсэн зүйл үүнтэй адил үнэхээр итгэхийн аргагүй байна. Бидний энэхүү эргэлзээг тайлж, учрыг тайлбарлаж өгөх аваас ирэх цагийн хүмүүс эргэлзэх зүйлгүй бурхан багшийн сургаалд итгэж, тахиж болмой.”

Ингээд Шагжамүни будда дараах “Түүнчлэн ирсний насны хэмжээ хэмээх 16-р бүлэг”-т энэхүү асуултанд хариулж, бурханы жинхэнэ дүрийг тодорхойлдог.



Амьсгалдаа анхаарлаа төвлөрүүлэх нь

Мэдээж хэрэг амьсгал бол хүн амьд явахад зайлшгүй хэрэгтэй зүйл билээ. Жирийн хүний хувьд амьсгал гурван минут л зогсоход амь насанд халтай байх ба хүн анх эхээс төрөхдөө уйлангаа амьсгал авч, үхэхийнхээ өмнө богино амьсгал аваад тэнгэрт оддог билээ. Өөрөөр хэлбэл амьсгалах гэдэг өөрөө амьдрах гэсэн үг юм.

Шагжамүни Буддагийн сургаалд “Амьсгал авах ба гаргах сургаал” гэсэн судар байдаг. Энэ нь амьсгалаа авах ба гаргах үедээ “Би одоо гүнээр амьсгалж байна. Амьсгалаа гүнээр гаргаж байна” хэмээн амьсгалдаа сэтгэлээ төлөврүүлэн амьсгалах тухай сургаал юм.

Ингэж амьсгалдаа анхаарлаа төвлөрүүлж, амьсгалаа удаанаар авснаар “агуу их ач холбогдол ба агуу их ач буян” –ыг мэдэрч шунал төөрөгдлөөс ангижирч болдог байна. Өөрөөр хэлбэл, шунал төөрөгдөлд автагдахгүй, сэтгэл уужуу тайван болдог байна.

Тодруулан хэлбэл амьсгалдаа сэтгэлээ төлөврүүлэн гүн хурааж, удаан гаргахыг хэлнэ. Мөн түүнчлэн “баяр баясгаланг мэдэрч амьсгалая”, “сэтгэлээ тайвшруулан амьсгалая”, “бүх юм хувирч өөрчлөгддөг гэдгийг мэдрэнгээ амьсгалъя” гэх мэтээр бодож амьсгалж болно.

Ингэж амьсгалдаа сэтгэлээ төвлөрүүлснээр амьсгал өөрийн эрхгүй нам тайван болдог. Амьсгалаа ингэж үргэжлүүлснээр сэтгэл тогтворжиж, тархины үйл ажиллагаа сайжирна. Урт удаан амьсгалснаар тархи амарч,



мэдрэлийн системд эерэг нөлөө үзүүлж сэтгэл санаа тайвширахаас гадна бас тархины хүчил төрөгчийн хомсдолоос хамгаалдаг байна. Ялангуяа амьсгал гаргах явдал нь их чухал гэдэг бөгөөд энэ нь хүн төрөхдөө юуны өмнө амьсгалаа гаргаж уйлдагтай холбоотой болов уу.

Буддизм бол оюун ухамсрын сургаал юм. Хүн бүр жинхэнэ үнэний үйлчлэлийг мэдэрч, өөрийгөө удирдан тогтвортой байлгах нь чухал. Үүний тулд амьд явахын эх үндэс болох амьсгалаар дамжуулж бие, сэтгэлээ хянах нь хамгийн хялбар арга юм.

Талархах сэтгэлийг төрүүлэх нь

Хятадын эртний Соожи хэмээх гүн ухаантны амьсгалын талаар үлдээсэн нэгэн сургаал байдаг: “Их хүн цээжээрээ амьсгалдаг бол энгийн ард хоолойгоороо амьсгалдаг”.

Энэ үгнээс харахад цээжнээсээ авсан гүн амьсгал нь намуухан дөлгөөн, чадварлаг хүнийг төлөвшүүлдэг гэсэн үг бөгөөд үнэхээр л сэтгэл тогтворгүй болох, уурлах, сандрах үед амьсгал богиносож, хурдан болдог.

Энэ утгаараа гүн амьсгал авах нь үнэхээр чухал боловч бид өдөр тутамдаа санаа алдах үедээ л амьсгалаа гүн авдаг болохоос биш тэр болгон гүн амьсгал авъя хэмээн амьсгалдаа сэтгэлээ төвлөрүүлээд байдаггүй. Гэвч үнэндээ бол өдөр тутам гүнзгий амьсгал авч байх нь чухал юм.

Жишээлбэл өглөө оройн судар уншлагын дараах 3-5 минутыг амьсгалаа тогтворжуулахад зориулбал ямар вэ?

Бурханыхаа өмнө өвдөглөн сууж, хоёр өвдөгнийхөө хооронд хоёр атгасан

гарны хэмжээтэй зай авч, цээжээ тэнийлгэн нуруугаа тэгшилж засна. Завилж суугаад хийсэн ч болно. Амьсгалаа амаараа удаан гаргаж, хамраараа амьсгал авна. Ингэхдээ дээр өгүүлсэнчилэн амьсгалах бүрдээ сэтгэлээ төвлөрүүлснээр бие ч сэтгэл ч тайвширч ирнэ. Ийнхүү амьсгал ба зүрх нэг хором ч амардаггүй гэдгийг, амь насны гайхамшгыг мэдэрснээр бусдын ачаар амьд явж байгаадаа талархах сэтгэл төрнө. Энэхүү гэгээрэл нь биднийг шунахай, бардам сэтгэлтэй болохоос хамгаалж, өөрийгөө удирдан хянах гэсэн гайхалтай үр дүнг өгөх болно.

“Косэй” 2012 оны9 сарын дугаараас



Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

Рисшо Косей Кай Нийгэмлэгийн Ирээдүйн Ерөнхийлөгч
Нивано Коошо

Дэмжигч нарын бүлэг

Тэр үдэш би гэртээ долоо хоногийн дараа эргэж ирсэн юм. Нар аль хэдийн жаргаж, гадаа тас харанхуй болчихсон байсан ч намайг хүлээж ядсан дунд ба бага охин хоёр маань нүдээ гялалзуулан гүйж ирж тосов. “Ээж нь ирлээ”, “Ээж ээ, сайн явж ирсэн үү?” гээд охид маань намайг тэврэн угтав. Охидынхоо царайг хараад сэтгэл тайвширч, асуух зүйл ч ар араасаа урсан гарав: “Миний хөөрхөн хүүхдүүд, ээжийгээ байхгүй хойгуур маш сайн байсан байна. Эгч нь сайн уу, дүү нь сайн уу? Аав нь ажлаасаа ирээгүй байна юу? Сургууль нь гайгүй юу?” “Бүгд сайн, ээж ээ. Дүү найзтайгаа гадаа тоглоод ядраад унтчихсан. Эгч аав хоёр харьж ирээгүй байна” хэмээн хариулангаа охид маань намайг тэвэрсээр байв.

Гадаадад ажлаар явж ирээд гэртээ харьж ирэхэд гэрийнхэн маань ийнхүү намайг инээмсэглэлээр угтан авахад бүх ядаргаа тайлагдах шиг болдог. Гэртээ орж ирээд ачаагаа задалж янзалж суух ч завгүй шууд л гэр орны ажил эхэлдэг. Гэвч энэ нь би үнэхээр бусдад хэрэгцээтэй, шаардлагатай байгаагийн тэмдэг гээд бодохоор эрч хүчтэй болдог.

Үргэлж л хүүхдүүдтэйгээ зууралдаж байдаг болохоор хааяа нэг ганцаараа байхсан гэж боддог байсан боловч анх удаа гадаад уруу ганцаараа ажлаар явах үед хүүхдүүдээ санаад уйлж байсан юм. Хүүхдүүд маань “Ээж ээ, та битгий санаа зов. Цагаа тулахаар бид чаднаа. Та харин ажилаа сайн хийгээрэй. Бид таны төлөө залбирч байна. Хичээгээрэй” гэсэн имэйл өдөр бүр илгээж намайг дэмжиж байсан.



Нивано Кошо

Рисшо Косей Кай нийгэмлэгийн ерөнхийлөгч Нивано Ничикогийн том охин бөгөөд Токио хотод мэндэлсэн.

Хуулч мэргэжлээр их сургуулиа төгссөний дараагаар тус нийгэмлэгийн удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Такүрин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн. Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа нийгэмлэгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашны байгууллагатай хамтран ажиллах тал дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн тус нийгэмлэгийн дараагийн ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа.

Тэрээр нөхөр Мүнэхиро болон нэг хүү, гурван охины хамт амьдардаг.

Ажил үүрэг ямар чухал болох ба хүүхдийн хайр хоёр тэс өөр харьцуулашгүй зүйл юм. Хүүхдүүд маань заримдаа олон зүйлийг тэсэхээс өөр аргагүй болдог хэдий ч би хүүхдүүдээ ажлын төлөө золиослож байна гэж бодохыг хүсдэггүй. Хэрэв би хүүхдүүдээ хохироож байна гээд бодчихвол тэдний сэтгэлд тэр даруй хохирогчийн сүүдэр буучих болов уу гэж боддог юм. Хүүхдүүд маань хохирогч байтугай намайг дэмжигч бүлэг юм. Эх хүний хувьд мэдээж хэрэг зарим үед хүүхдүүдээ цаг гаргаж чадахгүй байгаадаа сэтгэл гуниглах үе байдаг. Гэвч энэ нь эхийн үрээ бодсон сэтгэлийн илрэл буюу эх үрийн холбооны илрэл билээ.

Бүх хэрэг санасны дагуу бүтэхээс илүү ямар нэг зүйлийн төлөө хүн өөрийнхөө хамгийн нандин зүйлээ өгч чадсан үед илүү их амьдралын амт, сэтгэл ханамжийг мэдэрдэг болов уу. Тийм ч учраас ажил үүрэгтээ илүү чин сэтгэлээсээ хандаж чаддаг. Ийнхүү би гэр бүлийнхээ ачаар, нөхөр хүүхдүүдийнхээ тусламж дэмжлэгийн ачаар ажил үүргээ хийж, бусдад бага ч болов тус нэмэр болохыг хичээж амьдарч байна. Хүүхдүүд маань ч үүнийг сайн ойлгож, өсөж том болж байгаа. Би харилцан бие биенийгээ хайрлах эх үрийн харилцааг тогтоохыг хүсдэг. “Уучлаарай” биш “баярлалаа” гэж хэлдэг болохыг зорьдог. Мөн би ч гэсэн хүүхдүүдийнхээ амьдралын дэмжигч байя хэмээн хүсдэг юм.

Гайхамшигт сургаалын ачаар анх мэдэрсэн аз жаргал дунд

Солонгос салбар, Ерөнхий ажлын хэлтсийн ахлагч
Фан Гён Жа

2012.05.28, Бурхан багшийн мэндэлсэн өдрийн баяр ёслол

Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Бурхан багш мэндэлсний 2550 жилийн ойгоор илтгэл тавьж байгаадаа би баяртай байна.

Би 2001 оны 3-р сарын 15-ны өдөр нийгэмлэгт элсэж орсон бөгөөд тус оныхоо 12 сард бурхан залж авсан. Тухайн үед ариун ордны эмх цэгцтэй байдал, нарийн дэг жаягаас ядарснаад сүүлийн өдөр хоол хоолойгоор давахгүй байсныг санаж байна. Үргэлж өөрийгөө хамгийн түрүүнд тавьдаг байсан надад бусдын төлөө, хүний төлөө бурханы үйл хийнэ гэдэг маш хүнд санагдаж байсан.

Миний бие нэг хүү гурван охинтой айлын бага охин болон мэндэлсэн билээ. 7 настай байхад минь ээж маань миний саналыг огт асуулгүйгээр хүүхэдгүй эгчийгээ өрөвдөн нагац эгчдээ намайг үрчлүүлсэн юм. Надгүйгээр хөгжилтэй гэгч нь хооллож буй гэр бүлийнхнийгээ хараад маш их ганцаарддаг байсан ч тэр бүгдийг дотроо нуудаг байв. Хэрэв намайг гэртээ харина гэвэл ээж, нагац эгч хоёрын харьцаа муудана гэж бодоод тэр талаар би огт дуугардаггүй байв.

Гэвч дотроо ганцаардан шаналж байгаа ч тэрийгээ ил гарган хэлж чадахгүй байгаа намайг огт анзаардаггүй эцэг эх болон хүйтэн хөндий нагац эгчийгээ үзэн яддаг байв. Эцэг эх шигээ хариуцлагагүй хүн болохгүй хэмээн бодож өссөн би хоёр охиндоо өөрийн амь амьдралаа зориулсан бөгөөд ингэх нь тэдний амьдралыг жаргалтай

болгоно хэмээн итгэдэг байв. Тэгээд дотроо хүүхдүүдээ эмч болгоно, телевизийн хөтлөгч болгоно гэх зэргээр бүгдийг бодож төлөвлөсөн байв. Охидууд маань ч итгэлийг минь эвдэлгүй сайн хүмүүс болон өсөж хүмүүжсэн.

Нэг өдөр хичээл сурлагадаа тэргүүлдэг бага охин маань их сургуулийн элсэлтийн шалгалтдаа унаж орхив. Өдийг хүртэл охиныхоо төлөө алдартай хийдэд 108 удаа, 3000 удаа өвдгөө шалбартал залбирсан би тэр мэдээг сонсоод цочролд орж, бодит байдлыг хүлээж авч чадахгүй харамсаж байсан.

Ахлах сургуулиасаа хойш шүтсэн буддын шашнаас татгалзах бодолтой байх үед сургуулийн найз, эгч дүүс мэт дотно нөхөрлөсөн анд Ким Сонжя Рисшо Косей Кай(РКК) нийгэмлэгийг танилцуулсан билээ.

Үргэлж өөрийхөө зөв хэмээн боддог байсан надад анхандаа РКК-ын сургаал ямар ч утгагүй санагдаж, найз Кимийгээ ч тэндээс гаргах санаатай байв. Гэтэл тэргүүний илтгэлийг сонсоод миний бодол 180 градус эргэв. Мөнх бус гэдэг бурханы сургаалыг би аливаа зүйл удаан үргэлжилдэггүй гэсэн утгаар ойлгодог байв. Гэтэл нийгэмлэг дээр мөнх бус гэдэг нь аливаа зүйл байнга хувьсан өөрчлөгддөг гэсэн утгатай гэдгийг олж мэдэв. Мөн бид хязгааргүй олон учралын дунд харилцан биенээ түшиж, амьдарч, амьдруулж байгаа гэдгийг суралцав. Байнга хувьсадаг хорвоод яаж амьдарвал зохилтой вэ, мөн хойшид амьдралд юу ч тохиолдож болно гэдгийг маш тодорхой ойлгов.

Өөрийгөө өөрчилвөл бусад хүн ч өөрчлөгдөнө гэдэг сургаал миний хувьд том аврал болсон юм. Өнгөрсөн амьдралын хар бараан өдрүүд маань бурханы сургаалтай холбогдох үндэс болсон юм. Түүнчлэн намайг гомдоож зовоож байсан хүмүүс бол бурхан багшийн сургаалтай намайг ойртуулж түүнийг даган зөв амьдруулахын тулд гарч ирсэн бодьсатва нар байсан гэдгийг ухаарах үед тэдгээр хүмүүсийг үзэн ядах сэтгэл маань бага багаар алга болж эхлэв. Сэтгэл санаа тайван болоод ирэхээр бие маань сайжирч, эргэн тойрноо олж харах сөхөөтэй болж ирэв. Олон хүмүүс амьдралын зүг чигээ зөв залах луужингүй хэцүүдэж байгааг олж харав. Ингээд өөрийн эгч болоод хамаатан



Ерөнхий ажлын хэлтсийн ахлагч Фан ажлаа хийж байгаа нь

SPIRITUAL JOURNEY

саднуудаа нийгэмлэгт гишүүнээр элсүүлэв.

Ялангуяа миний хувьд зовлон ихтэй ээжтэй маань төстэй эгчийгээ хурдан аврагдаж аз жаргалтай болоосой хэмээн бодох сэтгэл маш их байснаас эгчийхээ сэтгэлийг ойлгоё гэж хичээлгүйгээр эгчийгээ өөрчлөх гэж бурханы сургаалиар бөмбөгдөн, эгчийгээ гэгээрүүлэх гэж улайрч байв.

Эгчийн маань нөхөр юу ч байхгүй газраас эхлэн өөрийн компаниа байгуулан ажиллаж байгаад гэнэт 40 насандаа нас барсан юм. Их хэмжээний өр, бага насны гурван хүүхэдтэйгээ үлдэн амьдрахын төлөө ганцаардлаа тэвчин тэмцэж байгаа эгчийгээ ойлгож, сэтгэлийг нь хөнгөвчлөх гэхээс илүүтэйгээр эгчийгээ буруутган, эцэг эхтэйгээ харилцах харьцаа, мөн эргэн тойронтойгоо харьцах харьцаанд ямар нэг анхаарах зүйл байх ёстой хэмээн эгчийгээ буруутгаж байв. Гэвч сургаалын ачаар эгчтэйгээ харилцах харьцаагаа дахин эргэн харж, бусад гишүүдээс олон зүйлийг сурч, эгчийхээ ачаар олон зүйлийг ойлгож мэдэв.

2010 оны 1 сарын 15-нд нийгэмлэгийн дэд шибүчёогоос Ерөнхий ажлын хэлтсийн ахлагчийн үүргийг хүлээн авав. Том үүргийн дарамт болон дассан гишүүдээсээ холдсон ганцаардлаас болоод их шаналж байв. Хуучин хариуцаж байсан дүүргийн гишүүд бие биенээ өнгөлөн хамтдаа сэтгэлээ сайжруулахыг хичээж байгааг нь харахад атаархмаар санагддаг байв. Мөн дассан дүүргээсээ холдсоноор өдийг хүртэл анзаарч байгаагүй зүйлсийг харж эхлэв. Бичиг цаасны ажилд алдаа байх учиргүй хэмээн өөрийнхөөрөө зүтгэн эргэн тойрны хүмүүсээ эвгүй байдалд оруулан, энэрэнгүй сэтгэл дугааж байснаа олж анзаарав. Үүнээс хойш бурханы сургаалыг хамтдаа дагах санга нараа тав тухтай орчинд сургаал сурах нөхцөл бололцоог бүрдүүлэхээр хичээх болно.

РКК-тай амьдралаа холбоод 10 жил боллоо. Үүрэгтээ улайран шамдаж байх энэ хугацаанд охидууддаа хэт санаа тавьж, өөрийнхөөрөө байлгах гэсэн сэтгэл маань алга болсон юм. Том охин маань залуучуудын бүлгийн ахлагчаар сонгогдон үүргээ хичээгүйлэн хийж байгаа. Залуу хүн гэртээ бурхан залж, бурханы сургаалын дагуу зөв амьдралаар амьдрахыг хичээж байгааг харахад үнэхээр талархууштай. Амин өдрүүдэд нийгэмлэгээр зээгийн маань дуу хадахад би үнэхээр жаргалтай болдог. Мөн зээг маань өхөөрдөн эрхлүүлэх санга нартаа талархаж байна. Бид өөрсдөөсөө дээш дөчин үеэ тоолоход нэг тэр бум есөн зуун сая өвөг дээдэс байдаг гэдэг. Хязгааргүй эртнээс дамжин ирсэн амь насны холбоог бодоход сансар огторгуйн агуу амь насаар тэтгэгдэн амьдарч байгаа амь насны гайхамшигийг бахдаад баршгүй. Би болон бусад хүмүүс тус тусдаа бус би болон бусад хүмүүс бид

бүгд нэг агуу амь насаар тэтгэгдэн амьдарч байгаа гэдгээ ухаарах үед бусдын төлөө, хүний төлөө хийх үйл бүгд өөрийнхөө төлөө гэдгийг ойлгосон юм.

Бага охиндоо мөн бурханы сургаалыг өвлүүлэн дамжуулахыг би хүсдэг. Гэвч хүргэн маань Христийн шашинтай хүн тул охин маань “ээжээ би хичээж байгаа болохоор түр хүлээгээч” хэмээн хэлдэг юм. Гэхдээ охины маань сэтгэлд аль хэдийн бурханы сургаалын үр суусан хэмээн бодож байна. Үүсгэн байгуулагчийн зорьж байсан энх тайван манай гэрт ч ирнэ гэдэгт итгэж байна.

Тэтгэвэртээ гараад, гэртээ нам тайван амьдрах насан дээрээ өглөөний цайгаа тухтай бэлдэх ч завгүй нийгэмлэг үрүү явах намайг болгоомжтой яваад ирээрэй хэмээн үдэх нөхөртөө чин сэтгэлээсээ талархаж явдаг. Амьдралаас хүртсэн хамгийн том бэлэг бол яах аргагүй хань минь билээ. Чамдаа баярлалаа.

Бурхан багш сургаалд хүнийг оруулахад хир хэцүү вэ гэдгийг дараах байдлаар зүйрлэсэн байдаг. Модны хатсан навчийг бариад гал дотор орон шатаалгүйгээр буцаж гарч ирэхээс Оройн Дээд Цагаан Лянхуа сургаалыг нэг ч болтугай хүнд дамжуулан ойлгуулах хамаагүй хэцүү хэмээн айлдсан байдаг.

Гэхдээ нийгэмлэгийн тэргүүн, зөвлөх, мөн сургаалыг хамтдаа сурах, түшиж тулах санга нар байхад надад санаа зовох зүйл үгүй. Бурханы сургаалын замаар алхахад тусалж дэмжиж буй олон олон хүмүүст талархан, сургаалыг зөвөөр дамжуулна гэдгээ тангараглаж байна.




Баруун талаас Фан болон зөвлөх Ри Кёоко



Shanzai сэтгүүлд гишүүд бодит амьдрал дээр бурхан багшийн сургаалыг хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай нийтэлж байна. Та ч гэсэн өөрийн туршлагаа дэлхийн олон орны гишүүдтэй хуваалцахгүй биз? Холбоо барих хаяг: shanzai.rk-international@kosei-kai.or.jp

shanzai

Замыг мэдэж замнах нь



Буддизмд хүний туулах ёстой зам мөрийг тодорхой заасан байдаг. Гэтэл “Буддизмын нэр дор буддизм гэж хэлэхээргүй зүйл олон байна” хэмээн эрдэмтэн Накамүра халаглан хэлсэн байдаг. Энэ үнэхээр харамсалтай зүйл.

Буддизмд Мөргөлийн гурван эрдэнэ, Хуулийн гурван тамга, Хутагтын дөрвөн үнэн, Хутагтын найман мөр, Зургаан барамид зэрэг сургаалаар дамжуулан хүний туулах ёстой зам мөрийг тодорхой заасан байдаг. Тиймээс зүгээр л сохроор явах байх бус сургаалыг сайтар ойлгосны үндсэн дээр бурханы замаар алхахад болох юм.

“Замыг мэдэхгүйгээр замнахаас илүү мэдээд замнах” нь юунаас ч илүү чухал.

Сургаалыг зөвхөн сонсох төдийд бол хэнд ч ойлгомжтой зүйл мэт сонсогдож, түүнийгээ ойлгочихсон мэт бодох нь олонтой. Өөрөөр хэлбэл энэ нь “Замыг мэддэг атлаа замаар замнадаггүй” хүн болох амархан гэсэн үг юм. Эрдэмтэн хүн хүртэл үүнийг үе үе мартчихдаг талтай гэлцдэг.

Хэнд ч ойлгомжтой зүйл мэт санагдах сургаал байсан ч хэрэгжүүлж үзсэнээр л түүний үнэ цэнэ гарч ирж, гэрэл гэгээтэй зам харагдаж ирдэг юм.



Амьсгалаа засах дасгалыг хэрэгжүүлцгээ

Намайг Гакуринд сурч байх үед нэг багш маань “чиний амьсгал түргэн байна” гэж анхааруулж байсан удаатай. Тухайн үед би оюун санааны маш их хямралтай, эргэн тойрны өөрчлөлтөнд сэтгэл тогтворгүйтэх нь их байсан байх. Түүнээс хойш би гүнзгий амьсгалах гэж хичээдэг болсон юм.

Амьсгалаа засаж тогтворжуулснаар сэтгэл тайвширдаг юм байна лээ. Түүнчлэн сэтгэл хөөрөл болон эргэн тойрны өөрчлөлтөд сөргөөр хандах маань ч багассан мэт санагддаг. Нөгөөтэйгүүр туулсан туршлага, аливаа үйл явдлын жинхэнэ утга учир, үнэ цэнийг илүү олж анзаардаг болсон юм.

Та бүхэн амьсгалаа засах дасгалыг хэрэгжүүлж байгаа уу? Ерөнхийлөгч Нивано энэ сарын сургаалдаа айлдсанчилан, судар уншлагын дараа оюун санаагаа амьсгалдаа төвлөрүүлэн суух гэсэн дасгалыг хийгээд үзвэл ямар вэ? Амьсгалаа тогтворжуулах дасгал хийснээр сэтгэл, бие болоод амьдралд маш гайхалтай үр дүн гарах болно.

Тайнан салбар шинэ тэргүүнээ угтав

2012 оны 8 сарын 1-нд үүрэгт ажлаа хүлээн авсан Тайнан нийгэмлэгийн тэргүүн Цай Ли Чинийг танилцуулъя.

Цай гуай 2008 оны 12 сард Тайнан нийгэмлэг үүсгэн байгуулагдсанаас хойш дүүргийн ахлагчаар (шибүчо) ажиллаж байсан. Тайнан нийгэмлэгийн тэргүүн асан Чин Ян Чуан өөд болсноор тэрээр удаах тэргүүнээр сонгогдсон юм.

Тэрээр долоо хоногийн хугацаатай зохион байгуулагдсан Тэргүүний сургалтын хүрээнд нийгэмлэгийн дадлагаар явж, дэг жаягийн сургалтанд суусан ба 8 сарын 1-нд РКК-ын Ерөнхийлөгч Нивоногоос үүрэгт ажилаа хүлээн авжээ.

Түүнчлэн ТУЗ-ын дарга Ватанабэгаас “Бурхан багшийн сургаал дээр тулгуурлан гишүүдийг аз жаргалд хөтөлж, гишүүдийн сайн сайхны төлөө үргэлж залбирах хэрэгтэй” гэсэн удирдамж авав.


Ингээд Цай тэргүүний цаашдын ажил үйлс бүтэмжтэй байх болтугай хэмээн хүсэн ерөөе.



Рисшо Косей Кай байгууллагын тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон Хамтран үндэслэгч Наганума Мёоко нарын санаачлагаар үүсгэн байгуулагдсан. Манай байгууллага нь “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ын сургаалыг гол номлолоо болгосон эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл бурхан багшийн сургаалыг гэр, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлэх замаар дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн зорилготой хүмүүсийн нэгдэл юм.

Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикогийн удирдлага дор сургаал түгээх үйлсэд зүтгэж, шашны бусад байгууллага болон дэлхийн олон орны хүмүүстэй гар барин, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.



SHAN-ZAI Volume 84 (September 2012)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс, Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo, Japan 166-8537 TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail : shanzai@kosei-kai.or.jp
Senior Editor : Rev. Shoko Mizutani Editor : Ms. Etsuko Nakamura Editorial Staff: Ms. Shiko Matsuoka, Ms. Yukino Kudo, Ms. Kaoru Saito, Ms. Mayumi Eto, Ms. Sayuri Suzuki, Ms. Eriko Kanao, Ms. Emi Makino, and Ms. Yurie Nogawa

Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Португал, Тай, Монгол хэл дээр тогтмол хэвлэгдэн гарч байна. Зарим дугаар нь бусад орны хэл дээр хэвлэгдэх ториолдол байдаг.
Санал хүсэлт, сэтгэгдэл байвал дээрх хаягаар холбоо барина уу.
Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын хэлтэстэй холбоо барина уу.

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2012

Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432
e-mail: info@rkina.org http://www.rkina.org

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
http://www.buddhismtampabay.org/

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4265

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rkina.org/losangeles.html

Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
http://www.rkina.org/sanantonio.html

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
e-mail: rkssf@sbcglobal.net http://www.rkina.org/sanfrancisco.html

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattle@juno.com

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of Vancouver

Lotus Buddhist Circle

851 N. San Mateo Drive, San Mateo, CA 94401, U.S.A.
http://www.buddhistlearningcenter.com/

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: koseiny@aol.com http://rk-ny.org/

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel & Fax: 1-847-394-0809
e-mail: murakami4838@aol.com http://home.earthlink.net/~rkchi/

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: ok.risshokoseikai@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls
724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
Tel: 1-541-810-8127

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1571 Race Street, Denver, Colorado 80206, U.S.A.
Tel: 1-303-810-3638

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.
http://www.rkina-dayton.com/

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br http://www.rkk.org.br

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
Tel: 55-11-4724-8862

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjehng District, Taipei City 100
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Jilung

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,
Pingtung County 900
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Korean Rissho Kosei-kai of Masan

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong,
Special Administrative Region of the People's Republic of China
Tel: 852-2-369-1836 *Fax:* 852-2-368-3730

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
Tel & Fax: 976-11-318667
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sukhbaatar

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar,
Mongolia

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai (Geneva)

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland
Tel: 41-22-791-6261 *Fax:* 41-22-710-2053
e-mail: rkkgva@wcc-coe.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Venezia

Castello-2229 30122-Venezia Ve Italy
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Sydney

International Buddhist Congregation (IBC)

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Rissho Kosei-kai of Dhaka

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,
Dahka Cand.-1206, Bangladesh
Tel: 880-2-8316887

Rissho Kosei-kai of Mayani

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Sri Lanka

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
Tel: 94-11-2826367 *Fax:* 94-11-4205632

Rissho Kosei-kai of Polonnaruwa

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,
Sri Lanka

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Galle

No.43 Melban Park Akmeemana, Galle, Sri Lanka

Rissho Kosei-kai of Kandy-wattegama

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

Branches under the South Asia Division

Delhi Dharma Center

B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
Tel: 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713
e-mail: sakusena@hotmail.com

Rissho Kosei-kai of West Delhi

A-139 Ganesh Nagar, Tilak Nagar
New Delhi-110018, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
Tel: 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832
e-mail: nrkk@wlink.com.np

Rissho Kosei-kai of Lumbini

Shantiban, Lumbini, Nepal

Rissho Kosei-kai of Singapore

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Other Groups

Rissho Kosei-kai Friends in Shanghai

1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 Ou Yang Road,
Shanghai 200081 China